



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 612

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нийслэл Улаанбаатар хотод барьж, ашиглалтад оруулсан нийт 44,020,260,610.00 (дөчин дөрвөн тэрбум хорин сая хоёр зуун жаран мянга зургаан зуун арван) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг Нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга Ч.Однасанд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгөөр нийслэлийн өмчит цэцэрлэг, сургуульд бий болсон барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002636

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 сарын 25-ний өдрийн
6.12 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Байршил /дүүргээр/	Хүлээн авч ашиглах төсөвт байгууллагын нэр	Барилга, байгууламжийн нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Сүхбаатар	135 дугаар цэцэрлэг	Өргөтгөлийн барилга	1,676,737,842.00
2	Сүхбаатар	Монгол-Оросын хамтарсан сургууль	Өргөтгөлийн барилга	4,427,369,520.00
3	Сүхбаатар	11 дүгээр сургууль	Өргөтгөлийн барилга	3,330,262,236.00
4	Баянзүрх	48 дугаар сургууль	Давхрын өргөтгөл	1,170,725,415.00
5	Баянзүрх	84 дүгээр сургууль	Өргөтгөлийн барилга	3,818,971,615.00
6	Баянзүрх	33 дугаар сургууль	Спорт цогцолбор, бассейны барилга	2,735,265,141.00
7	Баянзүрх	115 дугаар сургууль	Өргөтгөлийн барилга	1,220,534,037.00
8	Сонгинохайрхан	104 дүгээр сургууль	Өргөтгөлийн барилга	3,840,000,000.00
9	Сонгинохайрхан	253 дугаар цэцэрлэг	Шинэ барилга	1,758,000,000.00
10	Сонгинохайрхан	228 дугаар цэцэрлэг	Шинэ барилга	1,200,000,000.00
11	Баянгол	95 дугаар цэцэрлэг	Давхрын өргөтгөлийн барилга	780,091,778.00
12	Баянгол	141 дүгээр сургууль	Шинэ барилга	14,392,925,505.00
13	Баянгол	262 дугаар цэцэрлэг	Шинэ барилга	3,669,377,521.00
	Нийт дүн			44,020,260,610.00
				(дөчин дөрвөн тэрбум хорин сая хоёр зуун жаран мянга зургаан зуун арван)